

## Төслийн нэр: Эцэг эхийн оролцоотой бүтэээ

### Хэсэг I: Төсөл санаачлагчийн мэдээлэл

Аймаг/ хот: Баян- Өлгий
Сум /дүүрэг: Буянт Шартохой 4-р баг
Сургууль, СЭЭБХ-ны хаяг: Буянт сумын ЕБС-ийн 23 тоот
СЭЭБХ-ны зохицуулагчийн овог, нэр: Сүрэнбэл Нарангэрэл (Утас: 9541 5120, и-мэйл: <a href="mailto:buyantseebkh@gmail.com">buyantseebkh@gmail.com</a> )

### Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Дотоод хүчин зүйлс	
<b>Давуу тал</b> <ol style="list-style-type: none"><li>2018 оны 10-р сард “Боловсролын чанарын шинэчлэл” төслөөр байгалийн ухааны хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан. Багш нар сургалтандаа ашиглаж, сурлагын чанарт тодорхой ахиц гарсан.</li><li>Бусад сургуулиас ялгарах онцлог -хос хэлээр сургалт явуулдаг.</li><li>Бага ангийн Монгол хэлний кабинеттай.</li><li>Багш нар багаар ажиллах арга зүй сайн эзэмшсэн</li><li>СЭЭБХ-ноос зохион байгуулан багш нар дотуур байрны сурагчдад давтлага өгч ажиллаж байна.</li><li>Хүүхэд хөгжлийн танхимтай</li><li>СЭЭБХ-ны үйл ажиллагаа тогмолжсон.</li><li>Багш нар техник хэрэгслийг ашиглах, хэрэглэх чадвар сайн.</li><li>Орон нутагтаа нийтийн болон сургуулийн номын сантай</li><li>Ангиуд ангийн номын сантай.</li></ol>	<b>Сул тал</b> <ol style="list-style-type: none"><li>Кабинетийн системээр хичээллэх боломжгүй.</li><li>СӨБ-д хөдөөгийн малчдын хүүхэд хамрагдаггүй учир сургуульд харилцан адилгүй түвшинтэй хүүхдүүд орж ирдэг. Тухайлбал 2018 онд сургуульд элсэн суралцагчдын 38.5% нь СӨБ-д хамрагдаагүй байна.</li><li>Багш,эцэг эхийн харилцаа холбоо сул</li><li>СЭЭБХ өөрийн өрөөгүй</li><li>СЭЭБХ-ны гишүүдийн идэвх сул</li><li>Эцэг эхчүүд зориулагдсан ном, хэвлэл гарын авлага дутмаг.</li><li>Эцэг эхчүүдийн хүүхэдтэйгээ ажиллах арга зүй мэдлэг сул.</li><li>СЭЭБХ-ны үйл ажиллагаанд зориулсан тоног төхөөрөмж ашиглах материал байхгүй.</li></ol>
Гадаад хүчин зүйлс	
<b>Боломж</b> <ol style="list-style-type: none"><li>Ангиудын хүүхдийн тоо цөөн учир багш хүүхэд бүртэй ажиллах боломжтой.</li><li>Энэ хичээлийн жилийн аймгийн БСУГ-ын зорилтод эх хэлний хичээлийн чанарыг дээшлүүлэх асуудал тусгагдсан.</li><li>Багш нар хамтран ажиллах арга туршлагатай.</li><li>Зарим эцэг эхчүүд СЭЭБХ-ны үйл ажиллганд идэвхтэй оролцдог.</li><li>СЭЭБХ-ны үйл ажиллагаа тогтмолжсон</li></ol>	<b>Эрсдэл</b> <ol style="list-style-type: none"><li>Сурагчдыг хөгжүүлэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин байхгүй.</li><li>Багш эцэг эхийн уялдаа холбоо сул.</li><li>Эцэг эхийн мэдлэг дутмаг.</li><li>Сургуулийн төсөв хүрэлцээгүй, улирлын урамшуулал хангалттай авч чаддаггүй учир багш нар сэтгэл хангалуун ажиллах боломжгүй.</li><li>Багш нар хүүхдийг хангалттай сургаж, хөгжүүлж чаддаггүй</li><li>СЭЭБХ-ны гишүүдийн мэдлэг ур чадвар хангалттай биш</li></ol>

### Хэсэг IIБ. Төслийн зорилго, хамрах хүрээ

Зорилго	Математикийн хичээлийн чанарыг ахиулахад эцэг эх, багшийн хамтын ажиллагааг сайжруулж, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлнэ.
Хамрагдах хүний тоо	Бага ангийн нийт сурагч 198. Бага боловсролын нийт багш 10, Эцэг эх, СЭЭБХ-ын гишүүд, сургуулийн удирдлага.

### Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Төслийн нээлтийн үйл ажиллагаа	СЭЭБХ-ны УЗ	2019.6-р сард	Сургуулийн захиргаа, сумын удирдлагууд, эцэг эх, багш нарыг нээлтийн үйл ажиллагаанд урьж, СЭЭБХ-ны үйл ажиллагаа ач холбогдлыг танилцуулахаас гадна төслийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулна.
<b>Математикийн хичээлийн чанарыг ахиулах хүрээнд</b>				
2.	Эцэг эхчүүдтэй хамтран “МАТЕМАТИК”-ийн хичээлийн сонирхолтой хэрэглэгдэхүүн бэлдэх	Бага ангийн багш нар СЭЭБХ	2019 оны 9-р сараас улиралд нэг удаа	Гарын доорх материалыг ашиглан математикийн хичээлийн сонирхолтой хэрэглэгдэхүүний багцтай болно. Анги, бүлэг тус бүрээр
3.	“Дотуур байрны давтлагын цаг “	СЭЭБХ-ны гишүүд Эцэг эх	2019 оны 9-р сараас сард нэг удаа	Эцэг эхчүүд дотуур байрны бага ангийн сурагчидтай цагийн хуваарийн дагуу сонирхолтой хэрэглэгдэхүүнийг ашиглан тоо бодох, тоглох, харилцах ярилцах зэргийг цагийг хамт өнгөрөөснөөр дотуур байрны сурагчдын сурлагад ахиц гарна.
4.	Бага ангийн “Эцэг эхийн нэг өдөр “	1-5 ангийн эцэг эхчүүд СЭЭБХ багш	2019 оны 9-р сараас хуваарийн дагуу	Эцэг эхчүүд хичээлд сууснаар эцэг эх, багшийн харилцаа сайжирна, идэвхи оролцоо нэмэгднэ сурсан мэдсэн зүйлээ хүүхэдээ зааж сургана.
5.	Төслийн үйл ажиллагааг таниулах зорилготой сурвалжлах баг гаргах, багт зориулж сургалт зохион байгуулна. Баг төслийн бүх үйл ажиллагааны бичлэг хийж, түгээнэ.	СЭЭБХ, Аймгийн Хэвлэл мэдээллийн байгууллагаас дэмжлэг авна.	2019.9-р сард	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн үйл ажиллагаа бүрийг түгээх, сурталчлах “Эцэг эхийн сурвалжлах баг” гаргана.</li> <li>Бичих сонирхолтой эцэг эхийг сайн дурын үндсэн дээр энэ багт шалгаруулж авна.</li> <li>Сурвалжлах багийн бүтээлийг Sainsurguuli.mn сайт болон Сайн сургуулиас сайхан амьдрал эхэлнэ фэйсбүүк хуудсанд байршуулж, орон даяар түгээнэ. Мөн аймгийн ХМХ-ээр түгээнэ.</li> <li>Эцэг эхчүүдэд тараах материал байдлаар түгээнэ. Сургалтыг аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагаас арга зүйн дэмжлэг авч зохион байгуулна.</li> </ul>

6.	Хүүхдийн эрх, хамгаалал, хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас туршлага судлах	СЭЭБХ	2019.9-р сарын 24-27	Хүүхдийг ивээх сангийн “Хүүхэд хамгааллын арга зүйн төв”, Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төв, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, “Хүүхэд, өсвөр үеийг ивээх” төв
7.	Оролцогчид төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх	СЭЭБХ-ны төлөөллүүд	2019.10-р сар	Сургалт болон туршлага судлах хөтөлбөрийн хүрээнд сурсан зүйлээ өөрийн орон нутаг, эцэг эхчүүдэд хэрхэн түгээх, СЭЭБХ цаашид хэрхэн ажиллах талаар урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

**Эцэг эхийн оролцооны туршлагыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд**

8.	Сумын удирдлагуудтай хамтарч багуудийн хуралд оролцож СЭЭБХ-ны үйл ажиллгааг танилцуулан гишүүнчлэл нэмэгдүүлж “Батламж” олгоно.	СЭЭБХ УЗ гишүүд	2019 оны 9-р сараас багуудын хуралд	СЭЭБХ-ны гишүүн нэмэгдэнэ, малчин эцэг эх СЭЭБХ-ны үйл ажиллагаанд оролцох боломж бүрдэнэ. Батламж олгосноор эцэг эхчүүдэд итгэл найдвар бий болж хандлага өөрчлөгдөнө.
9.	Сурвалжлах багийн бүтээлийг эцэг эхчүүдэд түгээх	СЭЭБХ-ны УЗ болон гишүүд	2019 оны 10-р сараас сард нэг удаа	Төслийн үйл ажиллагаа, хийсэн хэрэглэгдэхүүний самбар, фэйсбүүк групп, мэдээллийн хуудас хэлбэрээр боловсруулан бүх эцэг эхэд түгээнэ.
10.	Математикийн хичээлийн хэрэглэгдэхүүний баяжилт хийлгэх эцэг эхийн цаг	СЭЭБХ-ны гишүүд Сургуулийн эцэг эхчүүд	2019 оны 10-р сараас Тогтмол	Нэмэлтээр хэрэглэгдэхүүн хийхэд бусад эцэг эхийг татан оролцуулна.
11.	Хоёрдогч түүхий эд ашиглан бага ангийн хүүхдийн чөлөөт цагаар тоглох тоглоом наадгай хийх, уралдаан эцэг эхийн дунд зарлах	СЭЭБХ-ны гишүүд Сургуулийн эцэг эхчүүд	2019 оны 10-р сараас Улиралд нэг удаа	Дотуур байрны хүүхдүүдэд зориулсан тоглоомын өрөө, математикийн хичээлийн хэрэглэгдэхүүний баялаг сайнтай болж, түүнийгээ хүүхэд бүрт ашиглуулна.
12.	Үр дүнгийн тайлан	СЭЭБХ	2020.4-р сар	Төслийн хугацаанд хийсэн үйл ажиллагааг тайлагнах, цаашид Хүүхэд-гэр бүл хөгжлийн өргөөг идэвхтэй, үр дүнтэй ажиллуулах төлөвлөлтөд санал, хүсэлт авна.

## Хэсэг IV Зардлын задаргаа

Зардлын төрөл	Хэмж их нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг	Тус бүрт нь хүрэх үр дүнг бичнэ. (Хүүхдэд ямар бодит үр дүн авчрах, ямар чадварыг эзэмшүүлэх)
Төслийн нээлт, хаалт үйл ажиллагаа • Баннер • Станд • Цайны материал	1 Удаа		200 000₮	200 000₮	Аймгийн болон сумын удирдлагууд, эцэг эх, багш нарыг нээлтийн үйл ажиллагаанд урьж, СЭЭБХ-ны үйл ажиллагаа ач холбогдлыг танилцуулахаас гадна төслийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулна.
• Хар принтер, сканертай • Ламинатор • Мэдээллийн самбар хийлгэх • Дуу хураагуур	Ш Ш Ш Ш	1 1 2 1	500 000₮ 120 000₮ 50 000₮ 120 000₮	500 000₮ 120 000₮ 100 000₮ 120 000₮	эцэг эхийн оролцоотойгоор математикийн хичээлийн хэрэглэгдэхүүний цуглуулагатай болж, хичээлээ бүтээлчээр заах боломж бүрдэнэ. Үүндээ эцэг эхийг татан оролцуулна.
Сурвалжлах багт зориулсан сургалт	Удаа	1	50 000₮	50 000₮	Сургалтын хэрэглэгдэхүүн цай кофе.
Эцэг эх, орон нутгийн хамтын ажиллагаа хэлэлцүүлэг	Удаа	1	20*3400 Урилга 20*300	78 000₮	Хэлэлцүүлэгт оролцох эцэг эхийн урилга цай кофе.
Туршлага судлах зардал	Удаа	1	189 000*5	945 000₮	УБ хотод байрлах, унаа болон бусад зардал
Туршлага судлах унааны зардал	2 талд	1	192 000*5	960 000₮	Баян-Өлгий аймгийн Буянт сумаас УБ хүртлэх замын зардал.
Туршлага судлах томилолтын зардал	хоног	4	30000-нэг хүнд	600 000₮	Сургалтанд хамрагдсан хүмүүсийн томилолт.
СЭЭБХ-ны гишүүд өөрийн орон нутгийн эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулна.	удаа	2	90*3400	306 000₮	Сургалтын хэрэглэгдэхүүн цай кофе.
Математикийн хичээлийн хэрэглэгдэхүүний баяжилт хийлгэх эцэг эхийн цаг	Удаа	10	100*3400	340 000₮	Сургалтын хэрэглэгдэхүүн цай кофе, эцэг эхэд урилга.
Хэрэглэгдэхүүний баяжилт хийлгэхэд зориулсан материалын худалдан авалт	Ш	50	50*6000₮	300 000₮	Хэрэглэгдэхүүн, материал авна.
Бичиг хэрэг	Б.дол		3*12000 10*1500 10*1000	111 000₮	Бичгийн цаас ,макар, ватум цаас
Харилцаа холбооны зардал	ш			100 000₮	Интернетийн зардал, утасны нэгж, шуудан холбоо

Хоёрдогч түүхий эд ашиглан бага ангийн хүүхдийн чөлөөт цагаар тоглох тоглоом наадгай хийх, уралдаан эцэг эхийн дунд зарлах				378 000₮	Гарын доорх материалыг ашиглан математикийн хичээлийн сонирхолтой хэрэглэгдэхүүний багцтай болно. Анги, бүлэг тус бүрээр
Үйл ажиллагааны зардал	ш		100 000	100 000₮	Хаалтын үйл ажиллагааны зардал.
Банкны шимтгэл				56 000₮	
Бүгд					<b>5 286 000₮</b>

#### **Хэсэг VI** Төслийн тогтвортой байдал

Тус сургуульд өмнөх оны Боловсролын чанарын шинэчлэл төслөөр байгалийн ухааны хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан. Багш нар сургалтандаа үр бүтээлтэй ашиглаж байна.

СЭЭБХ-ны чадавх бэхжүүлэх төсөл хэрэгжиж эхэлснээр эцэг эхчүүдийн болон СЭЭБХ-ийн гишүүдийн идэвх оролцоо нэмэгдэнэ. Эцэг эх чадавхжсанаар суралцагчдын сурлагын түвшинд ахиц гарна. Төсөл хэрэгжих явцад эцэг эх хүүхдийнхээ гэрийн даалгаварыг хэрхэн хийлгэх арга зүйтэй болсон байна. Эцэг эхчүүд гарын доорх материал ашиглан сургалтын хэрэглэгдхүүн хийдэг болно. Суралцагч, багш, эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагаа бэхжинэ. СЭЭБХ-ийн брэнд болох “Дотуур байрны” давтлага, “Эцэг эхийн нэг өдөр” гэх мэт үйл ажиллагаа тогтвортой явагдана.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр :

СЭЭБХ-ны Зохицуулагч: Нэр С.Нарангэрэл /Гарын үсэг.....*С.Н.Г*...../

Төслийг боловсруулсан:	Эцэг эх нэр: <i>У.Цолмон</i> / Н.Цолмон /	Огноо:
	Эцэг эх нэр: <i>Н.Чимгээ</i> / Н.Чимгээ /	2017 оны 07 сарын 07 дөр
	Эцэг эх нэр: <i>О.Дэнсмаа</i> / О.Дэнсмаа /	
	Эцэг эх нэр: <i>Б.Зоя</i> / Б.Зоя /	
	Багшийн нэр: <i>Т.Бадамцэцэг</i> / Т.Бадамцэцэг /	
	Багшийн нэр: <i>Б.Оюунхүү</i> / Б.Оюунхүү /	
	Багшийн нэр: <i>Х.Раяа</i> / Х.Раяа /	

